

ЗАХИРАЛ БАТЛАВ Ш.БАТЖАВ



[БАЯНДУН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ]

Огноо: 2020.01.10

**ҮДИЙН ЦАЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: **ҮДИЙН ЦАЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮНСНИЙ МАТЕРИАЛ**

ХУДАЛДАН АВАХ

Төслийн дугаар: **ДОАБДСЕБС /202001002/**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Дорнод аймгийн Баяндун сумын ЕБС-ийн суралцагчдын “Үдийн цай хөтөлбөр”-ийн хүнсний материал худалдан авах

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ДООБДСЕБС /202001002/

Дорнод аймгийн Баяндун сумын ЕБС-ийн суралцагчдын “Үдийн цай хөтөлбөр”-ийн хүнсний материал нийлүүлэх тендерт оролцохыг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим Төрийн худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж, дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу? Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын /www.e-procurement.mn дээр байгаа/ дагуу болон уламжлалтаар зохион байгуулж байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Дотоодын давуу эрх тооцно.

Тендерийг 2020 оны 02-р сарын 27-ны өдрийн 12 цаг 30 минутын өмнө доорхи хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн 13 цаг 00 минутад нээнэ.

Дорнод аймгийн Баяндун сумын

Дорнод аймгийн Баяндун сум, Наран баг, ЕБС-ийн 2 давхар

Утас: 89566078, 99584757

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь улсын зардлаар санхүүжих 43488000 төгрөгийн төсөвт өртөгтэй “Үдийн цай хөтөлбөрийн”-ийн хүнсний бараа материал нийлүүлэхэд дараах мэдээлэл болон үнийн саналыг ирүүлнэ. Тендерт оролцогч нь “Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь”-т заасан барааг нийлүүлэх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна.</p> <p>1.Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>2.Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>Бусад нэмэлт шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Байгууллага хувь хүний товч танилцуулга • Хүнсний материалуудын шинжилгээний бичиг • Тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн бичиг баримтын хуулбар • Машин, тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгслийн жагсаалт дэлгэрэнгүй мэдээлэл • Агуулах, лангууны аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх танилцуулга • Боловсон хүчний болон удирдах албан хаагчдын дэлгэрэнгүй судалгаа <p>Тухайлбал: <i>Хүнсний материал үйлдвэрлэх болон хүнсний материалын чиглэлээр худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байвал давуу тал болно.</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Баяндун сум Наран баг Наран хороолол Давхар болон өрөөний дугаар: Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны 2 давхарын 207 тоот өрөөнд</i></p> <p>Огноо: <i>2020 оны 02 дүгээр сарын 27-ны өдөр</i></p> <p>Цаг: <i>12:30 цагт</i></p>

ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Баяндун сум Наран баг Наран хороолол Давхар болон өрөөний дугаар: Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны 2 давхарын 207 тоот өрөөнд Огноо: 2020 оны 02 дүгээр сарын 27-ны өдөр Цаг: 13:00 цагт</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1. Мах махан бүтээгдэхүүн- 17640000₮ 2. Сүү, сүүн бүтээгдэхүүн-2945000₮ 3. Төмс хүнсний ногоо-8683100₮ 4. Талх нарийн боов-1572000₮ 5. Бусад хуурай хүнс-12647900₮

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ЗАХИРАЛ

2020.01.27

БАТЛАВ

Ш.БАТЖАВ



№	Барааны нэр	Барааны тодорхойлолт	Стандарт	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1. Мах махан бүтээгдэхүүн							
1	Үхрийн мах	Орон нутгийн	5-аас доош насны эрүүл мэндийн шаардлагыг бүрэн хангасан малын мах байх,	кг	2450	7200	17640000
Багц дүн-1							
2. Сүү, сүүн бүтээгдэхүүн							
1	Үнээний сүү	Орон нутгийн	Малын гарал үүсэл орон нутгийн байх, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан цэвэр эко бүтээгдэхүүн байх	л	1500	1000	1500000
2	Ааруул			кг	30	10000	300000
3	Тараг			л	250	2500	625000
4	Цөцгий			л	20	6000	120000
5	Аарц			кг	200	2000	400000
6	Шар тос			кг	10	16000	160000
Багц дүн-2							
3. Төмс хүнсний ногоо							
1	Төмс	Орон нутгийн	нутгийн хөрсөнд тарьж ургуулсан эрүүл ахуйн шаардлага бүрэн хангасан эко бүтээгдэхүүн байх	кг	1800	1300	2340000
2	Байцаа			кг	1400	2000	2800000
3	Лууван			кг	680	1900	1292000
4	Манжин			кг	458	1700	778600
5	Сонгино			кг	260	2000	520000
6	Сармис			кг	40	8000	320000
7	Өргөст			кг	45	4500	202500
8	Брокли			кг	32	6500	208000
9	Бууцай			кг	16	6000	96000
10	Улаан лооль			кг	21	6000	126000
							2945000

Багц дүн-3		8683100			
4. Талх нарийн боов					
1 нарийн боов	Орон нутгийн	түүхий эд материалаар хийсэн байх, тоног төхөөрөмжийн хувьд стандартын шаардлага хангасан байх, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байх	Ш	Ш	
2 талх	Орон нутгийн		2400	500	1200000
	Багц дүн-4		248	1500	372000
	Багц дүн-4				1572000
5. Бусад хуурай хүнс					
1 Гурил	Дорнод	дорнод гурил ХХК-ны 1 дүгээр гурил	кг	900	1200
2 Гурил дээд	Дотоодын үйлдвэрийн	Дотоодын үйлдвэрийн дээд гурил		360	1480
3 Гурил 2-р	Дотоодын үйлдвэрийн		кг	80	1000
4 Будаа цагаан	Хятад, Япон, Солонгос	Шинжилгээний бичигтэй эрүүл ахуйн шаардлага хангасан байх	кг	630	2400
5 Будаа шар	Орос	Алейка, 900граммын савлагаатай	ш	30	2000
6 Будаа болсон	Монгол	Слава, 150 граммын савлагаатай	ш	25	6700
7 Будаа гурвалжин	Орос	Алейка, 800 граммын савлагаатай	ш	50	3500
8 Хөц будаа	Монгол	Сайн	ш	64	2200
9 Хэмхдэс	Монгол	Сайн	ш	48	2500
10 Будаа хүүхдийн	Орос	Алейка, 1 кг-ийн савлагаатай	ш	40	2000
11 Гоймон туузан	Монгол	Лавша 3 кг-ийн савлагаатай	ш	108	2500
12 Гоймон буржгар	Орос	Алейка	ш	90	2000
13 Бүхэл үрийн гоймон	Монгол	Лавша 3 кг-ийн савлагаатай	ш	48	4000

14	Ургамлын тос	Орос	Юг руси	ш	270	4000	1080000
15	Масло	Орос	Янта 82% тослогтой	кг	360	4100	1476000
16	Элсэн чихэр	Орос	Сайн чанарын	кг	450	2400	1080000
17	Жимсний чанамал	Орос	Агрико	ш	54	4000	216000
18	Давс	Монгол	Иоджуулсан	ш	133	1000	133000
19	Амтлагч	Орос	Роллтон	ш	226	1600	361600
20	Томат	Итали	лаазтай	ш	45	1950	87750
21	Шош лааз	Монгол	лаазтай	ш	32	3500	112000
22	вандуй	Монгол	лаазтай	ш	20	2500	50000
23	Хатаасан сонгино	Монгол	Сайн чанарын	ш	48	1200	57600
24	Лаврын навч	Монгол	Сайн чанарын	ш	20	1000	20000
25	Хуурай цай	Монгол	Сайн чанарын	ш	36	7450	268200
26	Жимсний цай	Орос	Сайн чанарын	ш	15	2800	42000
27	Липтон цай	Малайз	Сайн чанарын	ш	15	3500	52500
28	Үзэм	Орос	Сайн чанарын	кг	80	7200	576000
29	чангаанз	Орос	Сайн чанарын	кг	30	11200	336000
30	Хар чавга	Орос	Сайн чанарын	кг	30	14400	432000
31	Чацаргана шүүс	Монгол	Сайн чанарын	кг	40	6500	260000
32	Нохойн хошуу	Монгол	Сайн чанарын	ш	20	5000	100000
33	Алаг салат	Монгол	Сайн чанарын	ш	90	2900	261000
34	Өөг салат	Монгол	Газар шим	ш	90	2800	252000
35	Далайн байцаа	Солонгос	Сайн чанарын	ш	240	2520	604800
36	Шөлний далайн байцаа	Солонгос	Сайн чанарын	ш	30	5500	165000
37	цагаан гаа амтлагч	Монгол	Сайн чанарын	ш	1	950	950
38	Эсгэгч	Хятад,	Сайн чанарын	ш	167	200	33400
Багц-5 дүн							12647900
Нийт							43488000

ЖАГСААЛТ ГАРГАСАН:НЯРАВ *Тайвал* Б.БАЙГАЛМАА

- Баглаа, боодол:** Манай байгууллагад нийлүүлж буй Үдийн цай хөтөлбөрийн хүнсний материалын сав баглаа боодол нь хүнсний эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан хадгалалт хамгаалалт тээвэрлэлтийн горим алдагдаагүй байх шаардлагатай. Бараа бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт тээвэрлэлтийн үеийн сав баглаа боодлыг нийлүүлэгч тал хариуцлагатайгаар боож бэлтгэх

бөгөөд нэхэмжлэх болон зарлагын баримтыг бүрэн хариуцуулж манай байгууллагын ажилтанд хүлээлгэн өгнө. Ачааг хагарч гэмтэх, солигдох эрсдлээс урьдчилан сэргийлж хаяглаж ангилах шаардлагатай.

2. **Бараа хүргэх газар:** Баяндун сумын Наран багийн Наран хороололд байрлах Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр
3. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-Д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Бусад хуурай хүнс	Багц-5	2001 ш 2960 кг	ш,кг	Баяндун сум, Наран баг, Наран хороолол	2020 оны 03 сарын 15-ны өдөр	2021 оны 01 сарын 15-ны өдөр	
Талх,нарийн боов	Багц-4	2648	ш		2020 оны 03 сарын 15-ны өдөр	2021 оны 01 сарын 15-ны өдөр	
Төмс хүнсний ногоо	Багц-3	4752	кг		2020 оны 03 сарын 15-ны өдөр	2021 оны 01 сарын 15-ны өдөр	
Мах, махан бүтээгдэхүүн	Багц-1	2450	кг		2020 оны 03 сарын 15-ны өдөр	2021 оны 01 сарын 15-ны өдөр	
Сүү, сүүн бүтээгдэхүүн	Багц-2	1770л, 240кг	л,кг		2020 оны 03 сарын 15-ны өдөр	2021 оны 01 сарын 15-ны өдөр	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг |

тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.

- | | |
|--|---|
| 10. Үүргээ биелүүлээг үй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Тендерийн хүчинтэй дуусахаас өмнө байгууллагын захирлын тушаалаар томилогдсон комисс нэг удаагийн шалгалтаар техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор туршилт хийнэ. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн 1 хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ,4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

1 жил байна. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. |

5. Алданги оногдуулах (ГЕН - 9)
- 9.1. Алданги оногдуулах хувь: **0,5**
Алдангийн нийт дүн: **10**

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ¹

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ___ дугаар сарын ____-наас _____ оны ___ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

¹ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг²;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

² Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.